



МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА ХОВД АЙМГИЙН ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

УЛСЫН БОЛОН ОРОН НУТГИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНД БУЙ АЖЛЫН ДАВХАРДАЛ, ЗАРДАЛ БУУРУУЛЖ ТӨСВИЙН ҮР АШГИЙГ ДЭЭШЛҮҮЛЭХ ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН



*Төрийн байгууллагуудын бүтцийг оновчтой зохион байгуулж,
дотоод хяналтийг сайжруулах шаардлагатай байна.*

*Ховд хот
2017 оны 6 сар*

<u>Аудитын тайланг бэлтгэсэн:</u>	<i>Товчилсон үгийн тайлбар..... 3</i>
ҮАГ-ын харьяа Ховд аймгийн Төрийн Аудитын газар Дарга, тэргүүлэх аудитор Л.Галбадрах	<i>Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй, шалгуур үзүүлэлт..... 4</i>
Аудитын менежер А.Цэцэгсүрэн	<i>Оршил 5</i>
Ахлах Аудитор Д.Хишгээ	<i>Бүлэг 1. Ховд аймгийн төрийн албан хаагчдын тоо 2015 оны гүйцэтгэлээс 79.5, 2016 онд батлагдсан төлөвлөгөөнөөс 106.5 орон тоогоор нэмэгдсэн байна. Орон нутаг, Байгаль орчин, Мэргэжлийн хяналтын газраас бусад төсвийн байгууллагууд чиг үүргийн давхардалгүй ажиллаж байна..</i>
Аудитор Д.Мөнхтулга	<i>..... 6-12</i>
Д.Эрдэнэцэцэг Шинжээч Ц.Гантулга	<i>Бүлэг 2. Агентлаг, орон нутгийн төсвийн болон өмчийн байгууллагуудын бүтэц орон тоо чиг үүрэг өөрчлөгдөж төрийн үйлчилгээний цар хүрээ нэмэгдсэн боловч зарим агентлагуудын улсын байцаагч, мэргэжилтнүүдийн чиг үүрэгтэй давхардах ажлын ачаалал жигд бус батлагдсан орон тоо хэтрүүлэх төсвийн үргүй зардал буурахгүй байна.....12-14</i>
2017 оны 6 дүгээр сар	<i>Бүлэг 3. Орон нутгийн төсөвт байгууллагууд болон зарим агентлаг төрийн өмчит аж ахуйн тооцоот газрууд байгууллагынхаа бүтэц орон тоо, чиг үүргийн давхардалд хяналт тавьж ажиллаагүй байна..... 15</i>
Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 70432736 дугаарын утсаар харилцана уу.	<i>Ерөнхий дүгнэлт.....16</i>
ХАЯГ:	<i>Зөвлөмж.....17</i>
Ховд аймгийн Засаг даргын тамгын газар	<i>Тэргүүлэх аудиторын тушаал18</i>
	<i>Холбогдох байгууллагаас ирүүлсэн санал 19</i>
	<i>Хавсралт судалгаа.....</i>

Товчилсон үгийн жагсаалт

УИХ	Улсын Их Хурал
ТАГ	Төрийн Аудитын Газар
ААГ	Аймгийн аудитын газар
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн хурал
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ТЗШ	Тусгай зориулалтын шилжүүлэг
ТТЗ	Төсвийн төвлөрүүлэн захирагч
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
БЦГ	Байгалийн цогцолборт газар
ХК	Хязгаарлагдмал компани
ТШЗ	Төсвийн шууд захирагч
ААН	Аж ахуйн нэгж
ОН	Орон нутаг
НДХ	Нийгмийн даатгалын хэлтэс
ЭМТ	Эрүүл мэндийн төв
ХХҮХ	Хөдөлмөр Халамж үйлчилгээний хэлтэс
БОЭТ	Бүсийн оношлогоо эмчилгээний төв
БОАЖГ	Байгаль орчин аялал жуучлалын газар
ЭМГ	Эрүүл мэндийн газар

1.1 Аудит хийх бүрэн эрх, үндэслэл: Аудитыг Монгол Улсын Ерөнхий аудиторт Үндэсний Аудитын газраас 2017 онд нийлүүлэх бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний төлөвлөгөө Аймгийн ИТХ-ын захиалга, Тэргүүлэх аудиторов баталсан гүйцэтгэлийн аудитын төлөвлөгөө, удирдамжийг үндэслэн Төрийн аудитын тухай хуулиар олгогдсон бүрэн эрхийн хүрээнд хийлээ.

1.2 Аудитын зорилт, хамрах хүрээ: “Улс орон нутгийн төсвийн болон орон нутгийн өмчийн байгууллагуудын үйл ажиллагаанд буй ажлын давхардал, зардал бууруулж төсвийн үр ашгийг дээшлүүлэх” аудит хийж дүнг аймгийн ИТХ, Засаг дарга, холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилт чиглэгдэнэ. Уг зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудит хийнэ. Үүнд:

- Засгийн газрын бодлогыг хэрэгжүүлэх улсын болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар, төсвийн байгууллагууд бүтэц чиг үүргийн хуваарилалтыг оновчтой байдлаар хууль тогтоомжид нийцүүлсэн ажиллаж байгаа эсэх
- Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар болон төсвийн байгууллагуудын удирдлага, зохион байгуулалтыг боловсронгуй болгох замаар төсвийн хөрөнгийг хэмнэх, төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг дээшлүүлэх талаар
- Аймгийн ИТХ, Засаг даргаас чиг үүргийн давхардалттай холбоотой өгөгдсөн шийдвэрүүдийн хэрэгжилт, дотоод хяналт, Улс, орон нутгийн төсвийн болон төрийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газруудын 2015-2016 оны үйл ажиллагаа, санхүүгийн баримт материалыг хамруулах бөгөөд түүврийн аргаар зарим төрийн байгууллагууд, иргэн, аж ахуйн нэгжийг хамрууллаа.

1.3 Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт, хугацаа: Аудитыг гүйцэтгэхэд Төрийн хяналт шалгалтын стандарт, Гүйцэтгэлийн аудитын удирдамж (АДБОУС 3000-3100)-ийг ашиглан, холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга лавлагаа болон судалгаа авах, харьцуулах, нэгтгэх, өгөгдөлд дүн шинжилгээ хийх, түүвэрчлэх, SWOT онилсон бүлэг, ажиглалт, ажил гүйлгээний сорил гэх зэрэг аудитын арга зүйг ашиглан нотлох зүйл цуглуулж, аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсруулна.

Аудитад дараахь хууль, тогтоомжийг шалгуур үзүүлэлт болгов. Үүнд: Төрийн Аудитын тухай хууль, Төрийн албаны хууль, Монгол улсын Засаг захиргааны нэгж түүний удирдлагын тухай хууль, Төсвийн тухай хууль, УИХ, Засгийн газраас гаргасан холбогдох шийдвэрүүд, МУЗГ-ын 2016 оны 81 тогтоол, 2015 оны 281 тоот тогтоол, 2015 оны 147 тоот тогтоол, хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдон гаргасан дүрэм, журам, аймгийн статистикийн хэлтсээс гаргасан мэдээ судалгаа, Төрийн албаны зөвлөлөөс гаргасан тогтоол, шийдвэр, холбогдох бусад хууль тогтоомжууд

ОРШИЛ

Ховд аймгийн хэмжээнд 2016 оны жилийн эцсийн байдлаар төсөвт 152 байгууллагад /сумдын ИТХ, ЗДТГ, Баг/ 5675 төрийн албан хаагч ажиллаж байгаагийн 16.8 хувь буюу 952 нь эрүүл мэндийн салбарт, 46 хувь буюу 2612 нь боловсролын салбарт, 15.6 хувь буюу 888 нь орон нутгийн төсөвт байгууллагуудад үлдэх 21.6 хувь буюу 1134 нь орон нутаг дахь яам агентлагын харьяа байгууллагад байна.

Нийт төрийн албан хаагчдын 5 хувь буюу 301 нь удирдах албан тушаалтан, 3 хувь буюу 173 нь дотоод нэгжийн дарга, орлогч, 61 хувь буюу 3494 нь мэргэжилтэн, 22 хувь буюу 1257 нь үйлчилгээний албан тушаалтан, 9 хувь буюу 414 нь байнгын болон улирлын чанартайгаар төрийн байгууллагуудад гэрээт ажилтанаар чиг үүргээ хэрэгжүүлжээ.

Төрийн албан хаагчдыг 2014 оны жилийн эцсийн төрийн албан хаагчдын тоотой харьцуулахад 37 хувь буюу 1545 төрийн албан хаагчаар нэмэгдсэний 519 нь яам агентлагын орон нутаг дахь 34 төсвийн байгууллагуудад нэмэгдэж, үлдэх 63 хувь буюу 1026 нь боловсрол, эрүүл мэнд, сумд дахь орон нутгийн 125 байгууллагуудад нэмэгдсэн байна.

2016 оны төсөвт 5569 орон тоо батлагдсанаас, гүйцэтгэлээр 5675 орон тоотой болж 106 орон тоогоор илүү ажиллаж байгаа судалгаа гарсан байна.

2013 онд ажиллаж байсан төрийн албан хаагчдыг 2016 оны эхний хагас жилд ажиллаж байгаа төрийн албан хаагчидтай харьцуулахад 38 хувь буюу 1592 төрийн албан хаагчаар өсжээ.

Судалгаанаас үзэхэд аймгийн 2015 оны статистикийн мэдээгээр хөдөлмөрийн насны 48852 хүн амтай харьцуулахад 8-9 хүн тутмын нэг нь төрийн албанд ажиллаж байна.

Мөн орон нутгийн өмчит 5 үйлдвэрийн газарт 252 хүн ажиллаж байгаагийн 81.7 хувь нь үйлчилгээний албан хаагчид байна.

2016 онд 60684.4 сая төгрөгийн зардлын төлөвлөгөөтэйгээс, гүйцэтгэлээр 59216.0 сая төгрөгийн зардал гаргаж батлагдсан зардлын төлөвлөгөөг 1468.4 сая төгрөгөөр хэмнэсэн боловч Төсвийн захирагчийн буруутай үйл ажиллагаанаас ажлаас халагдсан хүмүүсийн цалин буцаан олгож төсвийн үргүй зардал гаргасан алдааг тайлант онд мөн давтан гарсаар байна. Тухайлбал: Аймгийн ИТХ 8.0 сая, Жаргалант сумын 1 дүгээр сургууль 4.6 сая, 7 дугаар сургууль 4.3 сая, 3 дугаар сургууль 7.3 сая төгрөгийг тус тус шүүхийн шийдвэрээр олгожээ.

БҮЛЭГ 1. Ховд аймгийн төрийн албан хаагчдын тоо 2015 оны гүйцэтгэлээс 79.5, 2016 онд батлагдсан төлөвлөгөөнөөс 106.5 орон тоогоор нэмэгдсэн байна. Орон нутаг, Байгаль орчин, Мэргэжлийн хяналтын газраас бусад төсвийн байгууллагууд чиг үүргийн давхардалгүй ажиллаж байна.

2015 онд 5557 орон тоо батлагдсанаас гүйцэтгэлээр 5596 орон тоотой, 2016 онд 5569 орон тоо батлагдсанаас гүйцэтгэлээр 5675.5 орон тоотой үйл ажиллагаа явуулж 2015 онд 39, 2016 онд 106.5 орон тоо батлагдсан хэмжээнээс илүү ажилласан байна.

2016 онд батлагдсан орон тоог Боловсрол, соёлын сайдын багц 12, Эрүүл мэндийн сайдын багц 84, Байгаль орчны сайдын багц 4.5, бусад сайдын багц 24 орон тоогоор тус тус хэтрүүлж, хууль зүйн сайдын багц 4, шадар сайдын багц 1, орон нутгийн төсвийн байгууллагууд 9 орон тоогоор хэмнэж ажилласан байна. Төрийн албан хаагчдын тоо 2015 оны батлагдсан төлөвлөгөөнөөс 12, гүйцэтгэлээс 79.5 орон тоогоор нэмэгдсэн байна.

д/д	Үзүүлэлт	Он	Бүгд			Эзлэх хувь	
			Төл	Гүйц	Зөрүү	2015	2016
1	Боловсрол, соёлын сайдын багц	2015	2549	2561	-12	45.9	45.8
		2016	2600	2612	-12	46.7	46.0
	Өсөлт, бууралт		-51	-51	0		
2	Эрүүл мэндийн сайдын багц	2015	853	886	-33	15.4	15.8
		2016	868	952	-84	15.6	16.8
	Өсөлт, бууралт		-15	-66	51		
3	Хууль зүйн сайдын багц	2015	455	448	7	8.2	8.0
		2016	412	407	5	7.4	7.2
	Өсөлт, бууралт		43	41	2		
4	Шадар сайдын багц	2015	198	197	1	3.6	3.5
		2016	200	196	4	3.6	3.5
	Өсөлт, бууралт		-2	1	-3		
5	Байгаль орчны сайдын багц	2015	198	205	-7	3.6	3.7
		2016	204	208.5	-4.5	3.7	3.7
	Өсөлт, бууралт		-6	-3.5	-2.5		
6	ХХНХаламжийн сайдын багц	2015	116	115	1	2.1	2.1
		2016	106	106	0	1.9	1.9
	Өсөлт, бууралт		10	9	1		
7	Бусад сайдын багц	2015	285	285	0	5.1	5.1
		2016	282	306	-24	5.1	5.4
	Өсөлт, бууралт		3	-21	24		
8	Орон нутгийн төсөвт байгууллагууд	2015	903	899	4	16.2	16.1
		2016	897	888	9	16.1	15.6
	Өсөлт, бууралт		6	11	-5		
9	Нийт дүн	2015	5557	5596	-39		
		2016	5569	5675.5	-106.5		
	Өсөлт, бууралт		-12	-79.5	67.5		

1.1 Боловсролын салбарын бүтэц нь батлагдсан норм, норматив, орон тоо мөрдөн ажиллахгүй, батлагдаагүй орон тоон дээр ажилтан авч ажиллуулж байгаа нь төсвийн хөрөнгийн үр өгөөжийг бууруулж байна.

Тус салбарт 2015 онд 69 байгууллагын 2549 орон тоо батлагдсанаас 2561 орон тоотойгоор 2016 онд 2600 орон тоо батлагдсанаас 2612 орон тоотойгоор үйл ажиллагаагаа явуулжээ. Батлагдсан орон тоо нэмэгдэх болсон шалтгаан нь 14 дүгээр цэцэрлэг шинээр нээгдсэнтэй холбоотой байна. 2016 онд батлагдсанаас 14 орон тоо илүү ажиллаж байгаа нь сургуульд 8, соёлын төвүүдэд 1, цэцэрлэгт 3 орон тоо илүү ажиллажээ.

1995 оны 06 сарын 21-ны өдрийн Шинжлэх ухаан, боловсрол, Хүн амын бодлого, хөдөлмөр, Сангийн сайдын хамтарсан 126/97/114 тоот тогтоолыг зөрчин Алтай, Дуут, Дөргөн, Мөст, Манхан, Цэцэг, Үенч, Чандмань, Жаргалант сумын 3 дугаар сургуулиуд 921 хүүхэд хүрээгүй байхад номын санч, бичиг хэргийн ажилтануудыг тусад нь ажиллуулж байна.

- Мөн тушаалыг зөрчин Алтай, Дуут, Буянт, Дөргөн, Мөст, Мөнххайрхан, Мянгад, Манхан, Зэрэг, Ховд, Чандмань, Үенч, Жаргалант сумын 3 дугаар сургуулиудын сурагчдын тоо 901 хүрээгүй байхад сургуульд нэг эмч ажиллуулж байна.
- Сургуулийн өмнөх боловсрол олгох байгууллагад Буянт, Дөргөн, Мөст, Цэцэг, Зэрэг, Үенч, Чандмань болон аймгийн төвийн бүх цэцэрлэгүүд 9 хүртэл бүлэггүй байж арга зүйч ажиллуулж байна. Үенч сумын хүүхдийн цэцэрлэг 7 бүлэгтэй 3 тогооч, Жаргалант сумын 2, 4, 5, 6, 7, 10, 11, 13, 14 дүгээр цэцэрлэгүүдийн ангийн тоо 7 хүрээгүй байхад 2 тогооч ажиллуулж байгаа нь дээрх тушаалтай нийцэхгүй байна.
- 2016 онд орон тоо нь батлагдаагүй мужаан Дөргөн, Ховд сум, 2 дугаар сургууль, 7 дугаар сургуулиуд хичээл зохицуулагч, Цэцэг, Мөст, Мөнххайрхан, 1, 2, 3, 7-р сургуулиуд шатрын багш, мэдээлэл технологийн ажилтан зэрэг батлагдаагүй орон тоог ажиллуулж байна.
- Сургуулийн орон тоог батлахдаа харилцан адилгүй баталж байна. Тухайлбал: Алтай сумын сургууль 620 хүүхэдтэй нийт батлагдсан орон тоо 63 байхад Дарви сумын сургууль нь 600 хүүхэдтэй 71 орон тоо батлагдсан, ангийн тоо адил байхад багшийн тоог харилцан адилгүй баталжээ. 1000 хүүхэдтэй 36 бүлэгтэй 7 дугаар сургууль 89 орон тоотой, 1300 хүүхэдтэй 39 бүлэгтэй Цаст-Алтай сургууль 78 орон тоотой үйл ажиллагаа явуулж байгаа нь 7 дугаар сургуулиас 11 орон тоогоор дутуу ажиллаж байна. Иймд сургуулийн багш ажилчидын орон тоог холбогдох сайдын тушаал, шийдвэрийг үндэслэн батлахгүй байна.

1.2 Стандарт хэмжил зүйн газраас баталсан МУ-ын эрүүл мэндийн байгууллагуудын орон тоо стандартын дагуу батлагдаагүй байна.

Эрүүл мэндийн салбарт 25 байгууллага хамрагдаж 2015 онд 886 хүн, 2016 оны жилийн эцсээр 952 хүн ажиллаж байгаа нь сүүлийн 2 жилд 66 хүнээр нэмэгдсэн байна. 2016 онд 868 орон тоо батлагдсанаас гүйцэтгэлээр 952 орон тоо ажиллаж 84 орон тоогоор нэмэгджээ. Стандарт хэмжил зүйн газраас баталсан эрүүл мэндийн байгууллагуудын стандартаар 1108 орон тоотой ажиллахаас, 2016 оны гүйцэтгэлээр 952 орон тоо ажиллаж стандартаас 240 орон тоогоор дутуу ажилласан байна. 2016 оны батлагдсан орон тооноос БОЭТ 70, ЭМГ-т 5, Булган сумын нэгдсэн эмнэлэгт 3, Мөст сумын эмнэлэг 6 орон тоо тус тус илүү ажиллаж байна. Батлагдсан төсвөөс орон тоогоо хэтрүүлэн ажиллаж байгаа боловч эрүүл мэндийн салбарууд батлагдсан стандартаас дутуу орон тоогоор ажиллажээ.

Байгууллагууд	2016 орон тоо				
	Стандарт	Батлагдсан төсөв	Гүйцэтгэл	Батлагдсан төсвөөс	Стандартаас
ЭМГ	34	23	28	(5)	11
БОЭТ	530	359	429	(70)	171
ЗООНИЗ	22	22	22	-	-
Сумдын эрүүл мэндийн төв	366	343	343	-	23
Булган Нэгдсэн эмнэлэг	68	58	61	(3)	10
Мөст сум дундын эмнэлэг	36	23	29	(6)	13
Өрхийн эмнэлэг	52	40	40	-	12
Нийт дүн	1,108	868	952	(84)	240

БОЭТ-ийг MNS6330-4:2012 стандартын дагуу бүтэц орон тоогоор ажиллуулавал уг стандартаар 530 орон тоотой үйл ажиллагаа явуулахаар батлагдсан боловч 2016 онд батлагдсан 359 орон тоон дээр 429 ажилтан ажиллаж байна.

- Стандарт хэмжил зүйн газраас баталсан МУ-ын эрүүл мэндийн байгууллагуудын орон тооны стандартаас сумдын эрүүл мэндийн төвүүд болон сум дундын эмнэлэг 76, Бүсийн оношлогоо эмчилгээний төв 130, өрхийн эрүүл мэндийн төвүүдэд 28 буюу бүх салбарын хэмжээнд 240 орон тоогоор дутуу ажиллаж байна. Тухайлбал: Сумдын ЭМТ-дэд их эмч 11, багийн эмч 2, лаборант-5, сувилагч-11, эх баригч-4, вакцины сувилагч-7, ариутгаагч-13,

бусад ажилтан 10 дутуу байна. Энэ нь аймгийн эрүүл мэндийн салбарын төсвийн хүрэлцээгүйгээс орон тоог нэмэгдүүлэн батлуулаагүйтэй холбоотой байна.

1.3 Хуулийн байгууллагууд батлагдсан орон тоо дутуу, төрийн бусад байгууллагуудтай ажлын чиг үүргийн давхардалгүй байна.

Хууль зүйн сайдын салбарт Цагдаагийн газар, аймгийн болон Булган сум дахь Прокурорын газар, Булган сум дахь сум дундын, Анхан болон Давж заалдах шатны шүүх, Улсын бүртгэлийн хэлтэс, ШШГА, ШША зэрэг 9 байгууллага хамрагдаж байна.

Тус аймаг дахь Цагдаагийн газар нь Хууль зүйн сайдын багцын төсвөөс санхүүжилт орон тоог Цагдаагийн Ерөнхий газрын даргын тушаалаар тогтоон мөрдүүлдэг байна. Цагдаагийн газар нь 2015 онд 189, 2016 онд 192 орон тоотойгоор үйл ажиллагаа явуулахаар Цагдаагийн Ерөнхий газрын даргын тушаалаар баталсан боловч 2015 онд 188, 2016 онд 186 орон тоотой ажиллаж байна. 2015 онд 1, 2016 онд 6 орон тоо дутуу ажилласан байна.

✚ 2014 оноос өмнө сум дундын 2, давж заалдах шатны 1, Шүүхийн тамгын газар 2, нийт 50 орон тоотойгоор үйл ажиллагаа явуулж байсан бол 2014 онд анхан шатны 3, давж заалдах шатны 2 бүгд 5 шүүхийн 3 тамгын газартайгаар нийт 52 орон тоотой ажиллаж байгаад 2016 оны хагас жилээс үйл ажиллагаа нь нэгдэж 30 орон тоогоор ажиллаж орон тоо хэмнэгдсэн боловч цалингийн сан хэвээр байна.

✚ Аймгийн Прокурорын болон Булган сум дахь сум дундын прокурорын төсөв орон тоо цомхон үйл ажиллагаа нь бусад байгууллагуудтай давхардаагүй бүтцийн өөрчлөлт сүүлийн жилүүдэд хийгдээгүй байна.

1.4 Улсын байцаагчид нь байгаль орчны мэргэжилтэн, байгаль хамгаалагчид, ХАА-н чиглэлийн мэргэжилтэн, барилгын хяналтын мэргэжилтэнгүүдтэй чиг үүрэг давхардаж байна.

Шадар сайдын багцад Мэргэжлийн хяналтын газар 61, Стандартчлал хэмжилзүйн төв 11, Онцгой байдлын газар 113, Улсын нөөцийн салбар 12, бүгд 197 орон тойтойгоор ажилласан байна.

Дээрх байгууллагуудаас МХГ-аас бусад байгууллагуудын бүтэц орон тоо, чиг үүрэг нь бусад төрийн байгууллагуудтай давхцаагүй хэвийн ажиллаж байна.

Байгууллагууд	2016 оны орон тоо		
	Батлагдсан төсөв	Гүйцэтгэл	Зөрүү
Онцгой байдлын газар	113	113	0
МХГГазар	61	61	0
СХЗТөв	11	11	0
Улсын нөөцийн салбар	11	12	-1
Нийт дүн	196	197	-1

МХГ-ын санхүүгийн хяналтын тасаг нь 2015 оноос аймгийн Засаг даргын мэдэлд санхүүгийн хяналт, аудитын алба нэртэйгээр 6 орон тоотойгоор шинээр байгуулагдан ажиллаж байна.

Аймгийн хэмжээнд сумдад байгаль орчны байцаагч 17, байгаль орчны тусгай хамгаалалттай газарт 3, Тээвэр авто замын газарт 3, Мэргэжлийн хяналтын газарт 38 улсын байцаагч бүгд 61 улсын байцаагч ажиллаж байна.

МХГ-ын салбар хариуцсан байцаагчдын ажил зарим салбарт давхардаж байна.Тухайлбал: Байгаль орчны улсын байцаагч нар байгаль орчны байгууллагуудын мэргэжилтэн, байгаль хамгаалагч нартай байцаагчийн эрх авсан эрх аваагүйгээрээ ялгарч байгаа боловч ажлын чиг үүрэгт нь хяналт тавих,

хамгаалах гэсэн ажлын чиг үүрэг нэг байна. МХГ-ын байцаагч нарын ажлын байрны тодорхойлолтонд торгууль тавих гэж заасан боловч хүү торгуулийн орлого жилээс жилд буурч байна.

он	Хүү торгуулийн орлого			МХГ ийн хүү торгууль
	төл	гүй	зөрүү	
2015	258.0	177.3	(80.7)	15.0
2016	328.9	257.2	(71.7)	9.6
дүн	586.9	434.5	(152.4)	24.6

Аймгийн хэмжээнд 2015 онд хүү торгуулийн орлогыг 80.7, 2016 онд 71.7 сая төгрөгөөр тасалсан бөгөөд үүний 2015 онд 8.4 хувь нь 15.0 сая, 2016 оны 3.7 хувь буюу 9.6 сая төгрөг нь мэргэжлийн хяналтын хүү торгуулийн орлого эзлэж байна.

- Аймгийн хэмжээнд ажиллаж байгаа улсын байцаагчдын ажил хариуцах чадвар сул, байгаль орчин хөдөө аж ахуйтай холбогдолтой зөрчил дутагдал сүүлийн жилүүдэд эрс нэмэгдэж байхад торгууль шийтгэврийн орлого буурч байгаа нь ажлын үр дүнг торгууль шийтгэврийн орлоготой холбож хянадаггүй, мэргэжлийн бусад байгууллагуудтай улсын байцаагчид ажлаа уялдуулаагүйтэй холбоотой байна.
- Хөдөө аж ахуйн гаралтай мах, сүү, сүүн бүтээгдэхүүн, түүхий эд, газар тариалалтын үр дүнд бий болсон жимс, жимсгэнэ, хүнсний төрлийн бүтээгдэхүүнийг хот хооронд тээвэрлэх, зах дэлгүүрээр худалдан борлуулах, үйлдвэрлэх зэрэг төрөл бүрийн зөвшөөрлийг нэг хэсгийг Үйлдвэр хөдөө аж ахуйн газрын лаборториор, зарим хэсгийг нь МХГ-ын улсын байцаагчид болон лабортариор олгож байна.
- Аливаа зөвшөөрлийг мэргэжлийн байгууллагууд олгодог, хуулийн хүрээнд үйл ажиллагаагаа явуулж байгаа эсэхэд МХГ-ын улсын байцаагчид хөндлөнгийн хяналт тавьдаг чиг үүргийг тодорхой болгох шаардлагатай байна.

1.5 Байгаль орчны чиглэлийн байгууллагуудын чиг үүрэг давхардсан батлагдсан орон тооноос илүү орон тоотой ажиллаж байна.

Байгаль орчин, аялал жуулчлалын яамны харьяа Ус цаг уур орчны шинжилгээний төв, Байгаль орчин аялал жуулчлалын газар, Ой анги, Хар ус нуур орчмын улсын тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалтын захиргаа, Ховд гол хар нуурын сав газрын захиргаа, Үенч-Бодонч-Булган голын сав газрын захиргаа, Мөнххайрханы байгалийн цогцолбор газар, Цэцэг мянган угалзат байгалийн цогцолбор газар зэрэг 8 байгууллагад удирдах ажилтан 10, гүйцэтгэх ажилтан 176.5, үйлчлэх ажилтан 8 бүгд 208.5 орон тоотойгоор орон нутагт ажиллаж байна.

д/д	Байгууллагууд	Орон тоо		
		2015 он	2016 он	зөрүү /+ -/
1	БООЖГАЗар	40	40	0
2	Ой анги	3	5	-2
3	УЦОШАлба	95	95	0
4	Хар нуур Ховд голын сав газрын захиргаа	8	9.5	-1.5
5	ХУНОУТХГНХЗахиргаа	19	19	0
6	Мөнххайрхан БЦГ	18	17	1
7	Цэцэг МУНБЦГЗахиргаа	12	13	-1
8	Булган голын сав газрын захиргаа	5		5
9	Үенч Бодонч голын сав газрын захиргаа	5	10	-5
	Нийт дүн	205	208.5	-3.5

Тус байгууллагуудад 2013 онд 198 орон тоотой байсан бол 2016 онд 209,5 орон тоотой болж 11,5 орон тоогоор нэмэгдсэн нь Ус цаг уур орчны шинжилгээний төв 2, Байгаль орчин аялал жуулчлалын газар 2, Цэцэг мянган угалзат байгалийн цогцолбор 1, Хар нуур-Ховд голын сав газрын захиргаа 0.5 бүгд 5.5 орон тоогоор нэмэгдэж Мөнххайрханы БЦГХЗ-3, МУНБЦГХЗ 1 бүгд 4 орон тоогоор буурч, шинээр Ой анги 5, Үенч-Бодонч-Булган голын сав газрын захиргаа 10 бүгд 15 орон тоо шинээр нэмэгдсэн байна.

Ховд аймгийн Засаг даргын 2016 оны 11 сарын 14-ны өдрийн А/527 захирамжаар Байгаль орчин, аялал жуучлалын газрын бүтэц, орон тоог 39 байхаар баталсанаас, гүйцэтгэлээр 39 орон тоо ажилласан байна.

Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуучлалын сайдын 2015 оны 06 дугаар сарын 12 ны өдрийн А-233 тоот тушаалаар Тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалтын захиргаадын бүтэц, орон тоо болон сургалт мэдээллийн төвүүдийн байршлыг баталсан байна.

Монгол Улсын Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуучлалын сайдын 2016 оны 3 сарын 24 өдрийн А/83 тоот тушаалаар Булган голын сав газар, Үенч бодонч голын сав газрыг татан буулгаж Үенч-Бодонч-Булган голын сав газрыг 2016 оны 4 дүгээр сарын 01-ны өдрөөс эхлэн 9 орон тоотой байхаар баталжээ. Мөн дээрхи тушаалын 14 дугаар хавсралтаар Хар нуур-Ховд голын сав газрын захиргааг 9 орон тоотой байхаар баталжээ.

Олон улсын болон төсөл хөтөлбөрөөр санхүүждэг байгаль хамгаалах чиг үүрэгтэй төрийн бус байгууллагууд олон ажиллаж байгаа хэдий ч байгаль орчны газартай ажлын уялдаа холбоо төдийлөн сайн биш, ажлын давхардал чирэгдэл ч гарч байна.

- ✚ Хар ус нуур орчмын ТХГНХЗ-19, Мөнххайрханы БЦГ-18, Мянган Угалзатын БЦГ-12 бүгд 49 орон тоотой ажиллахаас Мянган Угалзатын БЦГ батлагдсан орон тооноос 1 орон тоо илүү байна.
- ✚ Ой ангийн чиг үүрэг Хот тохижуулахын ногоон байгууламж цэцэрлэгжүүлэлт хариуцсан албан хаагчидтай чиг үүрэг нь давхардалтай төдийгүй манай аймагт сонгуулийн үр дүнд ажилгүй болсон албан хаагчидад зориулан бие даасан байгууллага бий болгож жилд дунджаар 35.0 сая орчим төгрөгний зардал гаргаж байна.
- ✚ Байгаль орчны чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа дээрх 7 байгууллагад мэдээллийн ажилтан, сургалт суртчилгаа, хуулийн хэрэгжилт хариуцсан мэргэжилтэнүүдийн чиг үүрэг давхардсан 6 орон тоо байна. Сургалт суртчилгаа, хуулийн хэрэгжилт хариуцсан ажилчидаас гадна БОАЖГазар 2015 онд 38 удаагийн гадаадын болон дотоодын сургалт зохион байгуулж давхардсан тоогоор 210 хүн хамрагдсан байна.
- ✚ Ус цаг уур орчны шинжилгээний лаборторийн чиг үүрэг нь агаарын бохирдолт хяналт шинжилгээ хийж дүгнэлт гаргадаг чиг үүрэг нь БОАЖГазрын мэргэжилтэн, МХГ, Жаргалант сумын байцаагчидтай давхардаж байна.
- ✚ Үенч-Бодонч-Булган голын сав газар -1, Хар нуур-Ховд голын сав газар -1.5, МУНБЦГХЗ-1 бүгд 3,5 орон тоо батлагдсан хэмжээнээс илүү ажиллаж байна

1.6 Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны харьяа газруудад бүтцийн өөрчлөлт хийж ажлын чиг үүрэг өөрчлөгдөөгүй боловч зарим шаардлагагүй орон тоог бууруулах шаардлагатай байна.

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд нийгмийн халамж, хөдөлмөрийн хэлтэс, Нийгмийн даатгалын хэлтэс харьяалагдаж 2015 онд 135, 2016 онд 132 орон тоотой байна. Нийгмийн халамж үйлчилгээний хэлтэст хөдөлмөрийн асуудал хариуцсан 21 мэргэжилтэн шилжиж нэгдсэн боловч Халамж үйлчилгээний

Байгууллагууд	2015 орон тоо		Зөрүү	2016 орон тоо		Зөрүү
	Төлөвлөгөө	Гүйцэтгэл		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	
НДХ	50	50	0	50	50	0
Халамж	45	45	0	45	45	0
Асрамж	20	16	4	20	16	4
Хөдөлмөр	26	24	2	23	21	2
Нийт дүн	141	135	6	138	132	6

хэлтсийн орон тоо хэдэн үйлчлэгч, жолооч цөөн тооны мэргэжилтэнээр цөөрч ихэнх албан тушаал хэвээр үйл ажиллагаагаа явуулсаар байна. Тухайлбал: 2015 онд батлагдсан орон тоо Нийгмийн халамж-45, Хөдөлмөрийн хэлтэс-21, Асрамжийн газар -16 нийт 82 орон тоотойгоор үйл ажиллагаа нь хэвээр үргэлжилж бодитой хэмнэлт гараагүй байна. Бүтцийн өөрчлөлт хийж зарим орон тоо болон ажил үүрэг өөр хэлтсүүдэд шилжсэн боловч Нийгмийн Халамж үйлчилгээний хэлтсийн орон тоо 2015 онд ажиллаж байсан 45, Хөдөлмөрийн хэлтэс 21, Асрамж 16 орон тоотой тус тус үйл ажиллагаагаа явуулж байна.

- ✚ *Хөдөлмөр Халамж үйлчилгээний хэлтэсийн 4 мэргэжилтэн, Хөдөө аж ахуй, жижиг дунд үйлдвэрийн газрын 1 мэргэжилтэн татан буугдсан Хөдөлмөрийн хэлтсийн 21 хүний үүргийг гүйцэтгэж байсан бол даруй 5 дахин нэмэгдэж, зарим шинэ чиг үүргүүд давхардаж орон тооны хэмнэлт гараагүй байна*
- ✚ *Нийгмийн даатгалын хэлтэс нь 2015-2016 онуудад Эрүүл мэндийн сайдын тушаалаар баталсан орон тоогоор ажиллаж байгаа боловч дотроо 4 тасаг байгуулж тасаг бүр нэг даргатай ажиллаж чиг үүрэг нь давхардаж байна.*

1.7 Төсвийн байгууллагууд ажлын чиг үүргийн давхардалтай, сангийн яамны хянасан орон тоогоор ажиллаж байна.

Аймгийн ХХАА-н газар нь 2015 онд 25 орон тоотой байсан бол 2016 онд 27 орон тоотой болж жижиг дунд үйлдвэрлэлийн мэргэжилтэн 2 орон тоогоор нэмэгджээ. Аймгийн 17 суманд мал эмнэлэг үржлийн алба нь тус бүр 3 орон тоотойгоор сумын ЗДТГ-ын бүтэц зохион байгуулалтанд ажиллаж, мэргэжил арга зүйн зөвлөлгөө өгч нийт 51 хүн ажиллаж байна.

Сүүлийн жилүүдэд бүтэц орон тоо нэмэгдээгүй батлагдсан орон тоогоор ажиллаж байгаа боловч зарим нэг салбартай чиг үүргийн давхардал байсаар байна. Мөн аймгийн МХГ-т хөдөө аж ахуй, газар тариалангийн асуудал хариуцсан 2 улсын байцаагч, аймгийн ЗДТГ-ын хөгжлийн бодлогын хэлтэст хөдөө аж ахуйн асуудал хариуцсан мэргэжилтэн ажиллаж байгаа боловч тэдгээрийн ажлын уялдаа холбоо хангалтгүй, бие биенийхээ ажлыг давхардуулан гүйцэтгэдэг, ХХААГ-ын гүйцэтгэх үүргийг МХГ-ын улсын байцаагч нар давхар гүйцэтгэж зөвхөн торгууль шийтгэвэр тавих, мэргэжлийн байгууллагуудын хийсэн ажлыг хуулбарлах, зарим нэг зөвшөөрлийг мэргэжлийн байгууллагаас үл хамааралтай олгодог байна.

Авто тээврийн үндэсний төвийн аймаг дахь салбар нь тээврийн хэрэгсэлийн оношилгоо, үзлэг, бүртгэл, шилжилт хөдөлгөөн зэрэг мөнгөн орлоготой бүхий л үйлчилгээ зөвшөөрлийг хариуцан ажиллаж орсон орлогоо орон нутагт бус Авто тээврийн Үндэсний төвдөө төвлөрүүлдэгээс шалтгаалан ямар хэмжээний орлого олж байгаа, уг орлогыг юунд зарцуулдаг талаар орон нутагт ямар ч мэдээлэл хяналт байхгүй байна.

Дээрх орлогууд нь орон нутгийн иргэд хөдөлмөрчдийн үйлчилгээний болон зам ашигласнаас ордог тул уг орлогын тодорхой хэсгийг орон нутагт төвлөрүүлж зам засвар болон тээврийн хяналт бодлогыг зорилтыг хэрэгжүүлэхэд зарцуулдаг болгуулах шаардлагатай байна. Нөгөө талаар тээвэр оношилгооны салбарыг

аймагт харьяалуулж орон нутагт тээврийн хяналт, бодлогыг орон нутагт төвлөрүүлэх шаардлагатай байна.

1.8. Орон нутгийн төсвийн байгууллагууд ажлын чиг үүргийн давхардалтай, сангийн яамны хянасан орон тооноос илүү орон тоотой ажиллаж байна.

Сумдын ЗДТГ-ын бүтэц, орон тоо батлах тухай аймгийн Засаг даргын 2016 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн А/638 тоот захирамжаар Дарви, Дөргөн, Дуут, Мөнххайрхан, Цэцэг, Чандмань, Эрдэнэбүрэн сумын ЗДТГ-ыг 14, Булганаас бусад сумдыг 15 орон тоотойгоор ажиллахаар баталсан байна. Булган сумыг 15 орон тоогоор баталсан боловч санхүүгийн албаны нэг нягтлан бодогчийг хасаж оронд нь сумын засаг даргын орлогч 2 ажиллахаар баталсан байна.

Аймгийн иргэдийн төлөөлөгчдийн хурал нь Ховд аймгийн 2017-2020 оны стратеги төлөвлөгөөг ИТХ –ын 2017 оны 1 дүгээр сарын 11-ний өдрийн 4 дүгээр тогтоолоор баталж, уг төлөвлөгөөг үндэслэн аймгийн ИТХ-ын ажлын албыг 2 хэлтэс, 14 орон тоотой байхаар баталсан байх бөгөөд одоо 12 орон тоотой ажиллаж байна

- ✚ Аймгийн ИТХ нь Сангийн яамнаас батлагдсан орон тооноос 5 орон тоогоор илүү байна. Шинэ бүтэцээр хэлтсийн дарга нар ажиллах болж эдгээр дарга нарын ажлын байрны тодорхойлолт, гэрээгээр хүлээх ажил үүргийн хуваарь ажилтануудтайгаа давхцаж байна.
- ✚ Аймгийн төвийн сум нь хүн ам ихтэй, иргэдэд үйлчлэх байнгын үйлчилгээтэй иргэний танхим байх шаардлагатай гэсэн тайлбартай Жаргалант сумын ИТХ-д батлагдсан орон тооноос 1 ажилтан илүү байгаа нь аймгийн ЗДТГ-ын дэргэдэх иргэдээ сонсох танхимын ажилтны ажил үүрэгтэй давхцаж байна.
- ✚ Булган сумын Засаг даргын 2017 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн 04 тоот захирамжаар эдийн засаг, дэд бүтцийн асуудал хариуцсан орлогч, нийгмийн бодлогын асуудал хариуцсан орлогч гэсэн сумын засаг даргын орлогчийн орон тоог нэгээр нэмэгдүүлэн 2 орлогчтой ажиллаж байна.
- ✚ Сумдын ЗДТГ-ын бүтэц орон тоог баталсан захирамжаар 14 орон тоо баталж өгсөн сумдад Нийгмийн бодлого, хууль эрх зүйн асуудал хариуцсан мэргэжилтэн 1 ажиллахаар байхад 15 орон тоо баталсан сумдад ажиллах орон тоог задлан Нийгмийн бодлогын асуудал хариуцсан мэргэжилтэн 1, дотоод ажил, хууль эрх зүйн асуудал хариуцсан мэргэжилтэн 1 ажилтан ажиллахаар баталсан нь чиг үүргийн давхардал бий болгож байна.
- ✚ Аймгийн Засаг даргын нийгэм соёл хариуцсан орлогч, Нийгмийн бодлогын хэлтсийн даргын ажил үүргийг хавсран гүйцэтгэж байсныг аймгийн ЗДТГ-ын бүтэц батлахдаа Нийгмийн бодлогын хэлтсийг дангаар бий болгож дарга томилон ажиллуулж байгаа нь чиг үүргийн давхардал бий болгож байна.
- ✚ Засаг даргын нийгэм, соёл хариуцсан орлогч, нийгмийн бодлогын хэлтсийн дарга хоёрын аль нэг нь ажиллахад боломжтой гэж аудитын зүгээс үзэж байна.

1.9 Орон нутгийн өмчийн байгууллагуудын тухайн онуудын үйл ажиллагааны орлого, зарлагын дээд хязгаар, цалингийн санг аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн тогтоолоор баталдаг хэдий ч тэдгээр газруудын санхүүгийн төлөвлөгөөг зохих журмын дагуу салбар нэгж, зардлын ангиал бүрээр хуваарилан баталж мөрдүүлэх, түүний биелэлтэнд тухай бүр хяналт тавьж ажиллах Төлөөлөн удирдах зөвлөл үүргээ хангалтгүй биелүүлж байна.

Аймгийн хэмжээнд Шим Ус, Мянган Угалзат, Ховд суваргат, Чандмань Бит, Эрч хүч гэсэн таван ОНӨҮГ ажиллаж байна. Дээрх байгууллагуудад 2016 оны байдлаар 232 хүн ажиллаж байна.

Эрч ХХК-ны зарим ажилчид Хот тохижилтийн орон тоо дээр ажиллаж орон нутгийн төсвөөс цалинждаг, зарим ажилчид нь үйл ажиллагааны орлогоор цалинждаг, гүйцэтгэж байгаа ажил үйлчилгээ нь хот тохижилт үйлчилгээний ажил болон орон нутгийн хөрөнгө оруулалт, ОНХС-гийн хөрөнгөөр хийгддэг тендерийн хөрөнгө оруулалтын ажлыг авч гүйцэтгэж байгаа нь орон нутгийн өмчит байгууллагын статусыг зөрчиж төсвийн байгууллага ч биш, аж ахуйн нэгж ч биш хоёрдмол шинжтэй санхүүгийн зөрчилтэй байгууллага байна.

	Чандмань Бит төв	Мянган Угалзат ОНӨҮГ	Ховд суврага	Шим-Ус ХХК	Ховд эрч хүч	Нийт дүн
Орлого	19.0	139.1	66.3	1,282.5	452.4	1,959.3
Зарлага	30.3	182.6	85.5	1,468.5	468.6	2,235.5
2016 оны үр дүн	(11.3)	(43.5)	(19.2)	(185.9)	(16.2)	(276.1)

2016 онд аймгийн орон нутгийн өмчийн газрууд /-276,1/ сая төгрөгний алдагдалтай ажилласан байна. Нийт алдагдлын 67,3 хувийг Шим Ус ХХК, 15,7 хувийг Мянган угалзат ОНӨҮГ, 6,9 хувийг Ховд Суврага, 5,8 хувийг Эрч хүч, үлдэх 4,3 хувийг Чандмань Бит төв эзлэж байна.

Ховд Суварга ОНӨҮГ нь сүмийн статустай шашны үйл ажиллагаа явуулдаг боловч орон нутгийн төсвөөс санхүүгийн дэмжлэг авч байгаа нь Төсвийн тухай хуулийг мөн зөрчиж байна

Шим Ус ХХК нь 2014 онд салбарын хэмжээнд 69 орон тоотойгоор үйл ажиллагаа явуулж байсан бол 2016 онд 107 орон тоотой болж 38 орон тоогоор нэмэгдсэнээр тогтмол цалин хөлстэй ажилчдын цалин хөлс буурсан байна.

БҮЛЭГ2. Агентлаг, орон нутгийн төсвийн болон өмчийн байгууллагуудын бүтэц орон тоо чиг үүрэг өөрчлөгдөж төрийн үйлчилгээний цар хүрээ нэмэгдсэн боловч зарим агентлагуудын улсын байцаагч, мэргэжилтнүүдийн чиг үүрэгтэй давхардах ажлын ачаалал жигд бус батлагдсан орон тоо хэтрүүлэх төсвийн үргүй зардал буурахгүй байна.

Аймгийн хэмжээнд санхүү, төсвийн сахилга, хариуцлагыг сайжруулж, өр авлага барагдуулах талаар гарсан аймгийн Засаг даргын 2016 оны 07 дугаар “Албан даалгавар”, зарлага, санхүүжилтыг хугацаанд нь гаргах, хэмнэлтийн горимыг хэрэгжүүлж, оны эцэст аймаг, сумын хэмжээнд өргүй гарах арга хэмжээ авч сум, байгууллагуудад байнга үүрэг чиглэл өгч ажилласан байна.

2.1 Төсвийн захирагчийн буруутай үйл ажиллагаанаас ажлаас халагдсан хүмүүсийн цалин буцаан олгож төсвийн зардал гаргасан алдааг тайлант онд мөн давтан гарсаар байна. Тухайлбал: Аймгийн ИТХ 8.0 сая, Жаргалант сумын 1 дүгээр сургууль 4.6 сая, 7 дугаар сургууль 4.3 сая, 3 дугаар сургууль 7.3 сая төгрөгийг тус тус шүүхийн шийдвэрээр олгож үрэлгэн зардал гаргажээ.

2.2 Орон нутгийн төсвийн байгууллагуудын орон тооны давхардлыг МУ-ын Засгийн газрын 2014 оны 10 дугаар сарын 11-ний өдрийн “Төрийн албан хаагчийн албан тушаалын цалингийн сүлжээ, доод жишгийг шинэчлэн тогтоох тухай” 332 дугаар тогтоолын дагуу төрийн захиргааны албан тушаалын цалингийн дунджаар тооцоход 101.3 сая төгрөг хэмнэх боломж байна.

Байгууллага, албан тушаалын нэр	Илүү буюу давхцаж буй орон тоо	Сард олгох дундаж цалин /төг-өөр/	Жилийн дүн/ сая - төг/
Аймгийн ИТХ	5	509,9	30.5
Жаргалант сумын ИТХ	1	509,9	6.1
Булган сум /засаг даргын орлогч/	1	639,0	7.6
/дотоод ажил, хууль эрх зүйн асуудал хариуцсан мэргэжилтэн / 8 сум	8	509,9	48.9
Аймгийн ЗДТГ/нийгмийн бодлогын хэлтсийн дарга/	1	691,6	8.2
	16	0	101.3

2.3 Аймгийн төвийн нийт төсөвт байгууллагууд дулаан ашигласны төлбөрийг метр кубаар тооцон дулааны үйлдвэрүүдэд төлж байна. Тухайлбал: Жаргалант сумын 5 дугаар цэцэрлэг 2016 онд 4 сар дулааны тоолуураар ашиглан зөвхөн хэрэглэсэн дулааныхаа үнийг төлөхөд түлш халаалтын зардал нь 40 хувиар буурсан ч Дулааны өмнөх ашиглалтын захиргаа нь манайд алдагдалтай байна хэмээн тоолуурыг тасалсан нь Эрчим хүчний тухай хуулийн 16.3.3¹-д, мөн хуулийн 31.1²-д гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

2.4 БОЭТ нь клиникийн эмнэлэгийн зэрэглэлтэй, бүсийн статустай эмнэлэг боловч аймгуудын нэгдсэн эмнэлэгийн зэрэглэл орон тоо бүтэцтэйгээр үйл ажиллагаа явуулж байгаагаас шалтгаалан техник тоног төхөөрөмжөөр хангагдаж, нарийн мэргэжлийн өндөр ур чадвартай эмч мэргэжилтэн ажиллах боломжгүй тул эрүүл мэндийн салбарын орон тоо, төсвийн хувиарлалтыг оновчтой болгох шаардлагатай байна.

2.5 Эрүүл мэндийн салбарын хэмжээнд 2016 онд 868 орон тоо батлагдсанаас гүйцэтгэлээр 952 буюу 84 орон тоогоор илүү ажилласан байна. Тухайлбал: Булган Нэгдсэн эмнэлэг ор хоногийн төлөвлөгөөг биелүүлээгүй, өөрийн орлогыг бүрэн төвлөрүүлээгүй зуны цагт ачаалал багатай ажиллаж байгаа мөртлөө таван орон тоогоор илүү ажиллаж байгаа, ЭМГазарт ЭЭСангийн нягтлан бодогч, эмийн хангалт тоног төхөөрмж хариуцсан мэргэжилтэн, эмийн чанар бодлого хариуцсан мэргэжилтэн, статистик мэдээлэл хариуцсан мэргэжилтэн, статистикч бага эмч зэрэг чиг үүрэг нэг ажиллаж байгаа нь 550.5*84*12/ 554.9 сая төгрөгийн төсвийн үргүй зардал гаргаж байна. Батлагдсан орон тооноос илүү ажиллаж байгаа орон тоогоо нягтруулж дахин хянаж хамгийн багадаа 30 хүнээр орон тоогоо бууруулахад эмнэлгийн салбарын ажилчидын дундаж цалингаар тооцоход / 550.5*30*12/ 198.1 сая төгрөг бууруулж төсвөө хэмнэх боломж байна

2.6 Хуулийн байгууллагууд батлагдсан төсөв, бүтэц орон тоогоороо ажиллаж төрийн бусад байгууллагуудтай ажлын чиг үүргийн давхардалгүй ажиллаж байна.

¹ “Эрх бүхий байгууллагаар баталгаажуулсан цахилгаан, дулааны тоолуурыг холболтын цэгт суурилуулах”

² “Эрчим хүчээр хангагч, хэрэглэгчийн хооронд хийх эрчим хүчний хэрэглээний тооцоог эрх бүхий байгууллагын баталгаажуулсан тоолуурын заалтыг үндэслэн мөрдөгдөж байгаа тариф, гэрээний үний дагуу тооцно”

- 2.7 МХГ-ын зарим улсын байцаагч нар бусад салбарын мэргэжилтэнгүүдтэй чиг үүргийн давхардал үүсгэж байна. Тухайлбал: Байгаль орчны улсын байцаагч байгаль орчны газрын мэргэжилтэн, байгаль хамгаалагч нартай, ХАА хариуцсан улсын байцаагч ХАА-н газрын мэргэжилтэн, аймгийн ХАА-н бодлого хариуцсан мэргэжилтэнтэй, барилгын хяналтын байцаагч ГХБХБГазрын барилгын мэргэжилтэнтэй чиг үүрэг нь давхардаж байгаа 6 хүнийг төрийн захиргааны албан хаагчын дундаж цалингаар тооцвол 46,8 сая төгрөгийн төсвийн хэмнэлт гаргаж зарим чиг үүрэг давхардаж байгаа орон тоог бууруулах боломж байна. /БОСалбараас 2, ХАА-н газраас 2, Барилгаас 2 нийт 6*650.8*12/
- 2.8 Байгаль орчны яамны харьяа Үенч-Бодонч-Булган голын сав газар -1, Хар нуур-Ховд голын сав газар -1, МУНБЦГХЗ-1 бүгд 3 орон тоо батлагдсан орон тооноос илүү ажиллаж буй төрийн албан хаагчдын цалинг МУЗГ-ын 2014 оны 332 тоот тогтоолоор батлагдсан “Төрийн албан хаагчдын албан тушаалын цалингийн сүлжээ, доод жишгийг харгалзан тооцож үзвэл / 509,9*12*3/ 18,3 сая, чиг үүргийн давхардалтай 6 орон тоо/509.9*6*12/ 36.7 сая бүгд 55.0 сая төгрөг
- 2.9 Ойн ангийн чиг үүрэг Хот тохижуулахын ногоон байгууламж цэцэрлэгжүүлэлт хариуцсан алба хаагчдын чиг үүрэгтэй давхардаж байгаа тул ойн ангийг БОАЖГ-т нэгтгэвэл 35.0 сая төгрөг хэмнэгдэж төсвийн хөрөнгийн үр ашиг дээшлэнэ. Ойн ангийг төсвөөс цалинжуулахгүй аж ахуйн тооцоотой аж ахуйн нэгж хэлбэрээр ажиллуулах, Байгаль орчны чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа төрийн албан хаагчдын чиг үүргийн давхардалыг арилгавал улс, орон нутгийн төсөвт 90.0 орчим сая төгрөгийн хэмнэлт гаргах боломжууд байна.
- 2.10 Хөдөлмөр халамж үйлчилгээний ерөнхий газрын 2016.09.14-ны А/88 тоот тушаалаар Халамж үйлчилгээний хэлтэст Хөдөлмөрийн хэлтэс нэгдэж чиг үүрэг нь нэг болж үйл ажиллагаагаа явуулж байгаа боловч 2016 онд батлагдсан орон тоо хэвээр үйл ажиллагаагаа явуулж байна. Зарим чиг үүрэг нь давхардаж байгаа Хүн ам хөгжил, гэр бүл харицсан мэргэжилтэн ХГБХХэлтсийн Өрх гэр бүл хариуцсан мэргэжилтэнтэй, бүтэц дотроо программ мэдээлэлийн сан хариуцсан мэргэжилтэн хөдөлмөр эрхлэлтийн мэдээлэлийн сан хариуцсан мэргэжилтэнтэй, дотоод ажил хариуцсан мэргэжилтэн дотоод хяналт үнэлгээ хариуцсан мэргэжилтэнтэй, өрхийн мэдээлэлийн нэгдсэн сангийн өргөдөл хариуцсан мэргэжилтэн ажил мэргэжилийн чиг олгох зөвлөгөө өгөх мэргэжилтэнтэй чиг үүрэг нь давхардаж байгааг дахин нягталж үр өгөөжийг дээшлүүлж / дундаж цалин 495.8*5*12/ жилийн 29.9 төгрөгийн цалингийн сан хэмнэх боломж байна.
- 2.11 ХХҮХэлтэс нь 2016 онд ажлын байрны шаарлага хангахгүй, зориулалтын бус байрыг 500.0 сая төгрөгөөр худалдан авсан байгаа нь төсвийн хөрөнгийн үр өгөөжийг бууруулж тухайн байрны тогтмол зардалд сүүлийн хагас жилийн байдлаар 21.6 сая төгрөгийн зардал гаргасан байна. Тухайн байгууллага Мянган Угалзат ОНӨҮГ-ын байрыг сарын /504.2*4500/ 2.2 сая төгрөгөөр түрээсэлж байхад /2.2*12/ 26.4 сая төгрөгийн зардал гаргаж байсан бол шинээр худалдан авсан байранд багадаа /100.2*3,6/ жилийн 43.2 сая төгрөгийн зардал гаргаж 16.8 сая төгрөгийн үргүй зардал гаргаж байна.
- 2,11.НДХэлтэс Булган суманд ажиллаж байгаа 3 хүнд ажлын байр барьсан, аймгийн төвд ажлын байрны өргөтгөл барьж нэг корпус тэр чигээрээ бүрэн

ашиглалтгүй цахилгаан, дулааны үргүй зардал гаргаж байна. Тухайлбал: 2015 онд тогтмол зардалд 23,1 сая төгрөгийн зардал гаргаж байсан бол 2016 онд шинээр байр нэмэгдсэнээр 38,6 сая төгрөгийн зардал гарч 15,5 сая төгрөгийн зардлаар тогтмол зардал нэмэгджээ.

2.12 Шим Ус ОНӨААТҮГ-ийн 2012 оныг 2015 онтой харьцуулбал 38 орон тоо нэмэгдсэний 14 нь 3 сумын усан хангамж ариутгах татуургын төвлөрсөн шинэ системтэй холбогдон нэмэгдэж үлдэх 24 орон тоо үндэслэлгүй нэмэгдсэнтэй холбоотойгоор нэг сард 10.7 сая жилд 128.4 сая төгрөгний цалингийн зардал хэмнэж бүтэц орон тоог нягтруулах боломжтой.

2.13. Мянган Угалзат ОНӨҮГ-ын зочид буудлын байр одоог хүртэл ашиглалтгүй орон нутгийн өмч үрэгдэх нөхцөл бүрдсэн байгааг анхаарч өмч ашиглалтыг сайжруулах шаардлагатай байна.

БҮЛЭГ 3. Орон нутгийн төсөвт байгууллагууд болон зарим агентлаг төрийн өмчит аж ахуйн тооцоот газрууд байгууллагынхаа бүтэц орон тоо, чиг үүргийн давхардалд хяналт тавьж ажиллаагүй байна.

Төсвийн тухай хуульд заасны дагуу төсвийн ерөнхийлөн захирагчдын бүтцэд дотоод аудитыг хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий Санхүүгийн хяналт аудитын алба байгуулагдан ажиллаж байна.

Тус алба нь 2016 онд үйл ажиллагааны төлөвлөгөө, хяналт шалгалтын графикаар 8 сумын 56 төсөвт байгууллага болон аймгийн төвийн 45 төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар бүгд 101 байгууллагад хяналт шалгалт хийхээр төлөвлөж, гүйцэтгэлээр аймгийн төвийн 39 байгууллагад төлөвлөгөөт шалгалт хийж хяналт хэрэгжүүлбэл зохих байгууллагынхаа 38.6 хувийг хамруулсан тоон мэдээтэй байна.

3.1 Төрийн сангийн дотоод хяналтыг хэрэгжүүлдэг 1 мэргэжилтэн ажилладаг бөгөөд 2016 онд ганцхан Чандмань сумаас өөр газар хяналт хэрэгжүүлээгүй байна. Аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний хэрэгжүүлэгч агентлаг Байгаль орчны газрын 7 мэргэжилтэн мэргэжлийн бус өөр мэргэжлийн төрийн албан хаагчид ажиллаж байна. Хууль бус ан агнуур, зөвшөөрөлгүй ашигт малтмал ашиглах, хайгуул хийх, ашигласан талбайг нөхөн сэргээхгүй орхигдуулах зэрэг байгаль хамгаалалтай холбоотой томоохон зөрчлүүд их хэмжээгээр гарч газар авч байхад таслан зогсоох талаар хийсэн бодит ажил дээрх байгууллагуудад аль алинд нь хангалтгүй байна. Тухайлбал : Бичигтийн хөтөлийн ойн зурвас байгуулах ажил ,Усны төлбөрөө төлөөгүй, зөвшөөрөл авалгүйгээр ус ашигладаг, тусгай хамгаалалттай газар нутагт гэрээ байгуулж нөхөн сэргээлт хийлгэсэн боловч хэрэгжүүлсэн ажлын үр дүн хангалтгүй байгаас үзэхэд дотоод хяналт сул байна.

3.2 Орон нутгийн өмчийн байгууллагуудын орон тоо төсвийг Аймгийн ИТХ-аар баталж байгаа боловч орон тоо, төсвийн зарцуулалт, гүйцэтгэж байгаа ажил үүрэгт нь орон нутгаас тавих дотоод хяналт хангалтгүй байна. Жилээс жилд алдагдлын хэмжээ нэмэгдэж орон нутгийн төсөвт орон нутгийн өмч ашигласаны төлбөрийг ч

бүрэн төлдөггүй, олсон орлогоо дур мэдэн үргүй зарцуулдаг дутагдал байсаар байна. Тухайлбал:Шим Ус ОНӨААТҮГ-ын 2014-2015 оны орлого бүрдүүлэлт зарцуулалтан хийсэн гүйцэтгэлийн аудитаар дотоод хяналт сулаас 139.8 сая төгрөгийн төлбөр зөрчил илэрсэнээс 61.5 сая төгрөгийн төлбөрийн акт, 78.3 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага бичигдсэн байна.

3.3 Орон нутгийн өмчийн эд хөрөнгийг зориулалтын дагуу бүрэн үр дүнтэй ашиглах үйл ажиллагаа хангалтгүй, эд хөрөнгийн ашиглалтанд байгууллагын дотоодын болон орон нутгийн өмчийн албанаас тавих хяналт сул байгаагаас хөрөнгийн эзэмшилт, ашиглалт, захиран зарцуулалтын үр ашиг хангалтгүй байна.

3.4 Шилэн дансны тухай хуулийн 6.4.7-д “Байгууллагын бүтэц орон тоонд орсон өөрчлөлт”-ийг тухай бүр мэдээлнэ гэсэн зүйл заалтийг хэрэгжүүлж ажиллаагүй байна. Аймгийн төсөвт байгууллагууд нь Төсвийн тухай хуулийн 14.2.12³ дахь заалтыг мөрдөн ажиллаагүй байна.

ЕРӨНХИЙ ДҮГНЭЛТ:

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараахь дүгнэлт хийж байна.

- ✚ *Ховд аймгийн төрийн албан хаагчдын тоо 2015 оны гүйцэтгэлээс 79.5, 2016 онд батлагдсан төлөвлөгөөнөөс 106.5 орон тоогоор нэмэгдсэн байна. Орон нутаг, Байгаль орчин, Мэргэжлийн хяналтын газраас бусад төсвийн байгууллагууд чиг үүргийн давхардалгүй ажиллаж байна.*
- ✚ *Агентлаг, орон нутгийн төсвийн болон өмчийн байгууллагуудын бүтэц орон тоо чиг үүрэг өөрчлөгдөж төрийн үйлчилгээний цар хүрээ нэмэгдсэн боловч зарим агентлагуудын улсын байцаагч, мэргэжилтнүүдийн чиг үүрэгтэй давхардах ажлын ачаалал жигд бус батлагдсан орон тоо хэтрүүлэх төсвийн үргүй зардал буурахгүй байна.*
- ✚ *Орон нутгийн төсөвт байгууллагууд болон зарим агентлаг төрийн өмчит аж ахуйн тооцоот газрууд байгууллагынхаа бүтэц орон тоо, чиг үүргийн давхардалд хяналт тавьж ажиллаагүй байна.*

АУДИТЫН ЗӨВЛӨМЖ

Аудитын дүн дүгнэлтэнд үндэслэн Аймгийн ИТХ-ын дарга Д. Пүрэвганди, Засаг дарга Д.Галсандондог, нарт зөвлөх нь:

- 1995 оны 06 сарын 21-ны өдрийн Шинжлэх ухаан боловсрол, Хүн амын бодлого хөдөлмөр, Сангийн сайдын хамтарсан 126/97/114 тоот тогтоолоор батлагдсан норм, норматив зөрчсөн сургууль, цэцэрлэгийн удирдлагад хариуцлага тооцож, боловсролын салбарын төсвийн төлөвлөлтийг сайжруулах

³ Эрхлэх асуудлын хүрээнд хамаарах төсөвт байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх, чиг үүргийн давхардлыг арилгах, ажлын ачаалалыг нягтруулах, бүтээмжийг дээшлүүлэх зорилгоор чиг үүрэг, зохион байгуулалтын бүтцийг батлагдсан орон тооны хязгаар, төсөвт багтаан шинэчлэн тогтоох

- Ой ангийг аймгийн Байгаль орчин, аялал жуучлалын газарт нэгтгэн зохион байгуулах
- Аймгийн ИТХ сангийн яамны хянасан орон тооноос илүү орон тоотой ажиллаж байгаа, Булган сумын засаг даргын орлогчийн орон тоог нэгээр нэмэгдүүлсэн, Засаг даргын нийгэм, соёл хариуцсан орлогч, нийгмийн бодлогын хэлтсийн дарга чиг үүргийн давхардалтай ажиллаж байгааг шийдвэрлэх
- Мэргэжлийн хяналт, Авто тээврийн үндэсний төвын орон тоо бүтэц, чиг үүргийн асуудлаар холбогдох яаманд тавьж шийдвэрлүүлэх
- Аймгийн төв, Булган сумын ажлын байрны талбайн ашиглалт илүүдэлтэй, ХХҮХэлтэс ажлын байрны шаардлага хангаагүй албан конторыг хэт өндөр үнээр худалдан авсан, Мянган Угалзат ОНӨҮГазрын мэдэлд байдаг зочид буудал одоо хүртэл ямарч ашиглалтгүй байгаа нь төрийн болон орон нутгийн өмч үнэгүйдсэн, хоорондын ажлын уялдаа холбоо байхгүй, хэт үрэлгэн байдлыг арилгаж, ашиглалтгүй байр талбайн ашиглалтыг сайжруулах
- Аймгийн төвийн төсөвт байгууллагууд нийт 307371.2 м.куб талбайтай ба эдгээр байгууллагууд дулааны тоолуургүй байна. Иймд аймгийн төвийн төсөвт байгууллагуудыг дулааны тоолууртай болгож хэрэглэсэн дулааны үнийг нь төлүүлбэл жилд дундажаар 1278.0 сая төгрөгийн төсөв хэмнэх боломжтой байгаа тул Эрчим хүчний тухай хуулийн дагуу баталгаажуулсан дулааны тоолууртай болгох шаардлагатай байна.
- ЗДТГазрын дэргэдэх хяналт үнэлгээ шинжилгээний хэлтэс болон дотоод хяналт, аудитын алба бүтэц орон тоо, чиг үүргийн давхардалд хяналт тавьж хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах

ТАЙЛАНТАЙ ТАНИЛЦСАН:

ДАРГА. ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Л.ГАЛБАДРАХ

ХЯНАСАН:

АУДИТЫН МЕНЕЖЕР

А.ЦЭЦЭГСҮРЭН

БИЧСЭН:

АХЛАХ АУДИТОР

Д.ХИШГЭЭ

АУДИТОР

Д.МӨНХТУЛГА

ШИНЖЭЭЧ

Д.ЭРДЭНЭЦЭЦЭГ

Ц.ГАНТУЛГА